Түлхүүр үг: Монгол орон, шувууны олон янз байдал, нүүдлийн шувууд, хамгаалал, экосистем, биогеографи, тархалт

Хүлээн авсан 2025.11.13; хянан тохиолдуулсан 2025.11.23; зөвшөөрсөн 2025.12.27

 © 2025 Зохиогчид. [CC BY-NC 4.0 LICENSE](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/).

Оршил

Монгол орон нь төв Азийн их цөлийн хойд зах, Сибирийн тайгын өмнөд хэсэгт 1.5645.116 км² нутаг дэвсгэрийг хамрах ба дэлхийд газар нутгийн хэмжээгээрээ 18-т жагсдаг бөгөөд өргөргийн дагуу тогтох ба байгалийн 6-н бүс бүслүүр дамнан оршино [1]. Байгалын ялгаатай олон бүс бүслүүрт орших тул амьтны аймгийн зүйлийн бүрдэл ихтэй мөн Евроазийн нүүдлийн шувуудын гурван гол замналын (Зүүн Ази-Австрали-Азийн, төв Ази, баруун Ази-зүүн Африк) уулзвар бүсэд оршдог тул олон улсын ач холбогдол бүхий нүүдлийн болон суурин шувуудын үржлийн болон дамжин өнгөрөх гол нутаг болдог. Тухайлбал, Монгол орны нуурууд, намгархаг бүсүүд, тал хээрийн бүс нутаг нь нүүдлийн шувуудын түр амрах, хооллох, үржих чухал бүс нутгийн нэг юм [2].

Дэлхийн хэмжээнд ховордож буй болон эндемик зүйлүүд үрждэг, үржлийн үедээ дайран өнгөрдөг нь Монгол орныг шувуу судлал, хамгаалалтын ажилд чухал бүс нутаг болгодог.

Гэвч сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, газар ашиглалтыг өөрчлөх, амьдрах орчны доройтол, хүнсний хомсдол, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл зэрэг олон хүчин зүйлс Монгол орны шувуудын популяцид сөргөөр нөлөөлж хамгаалалтын арга хэмжээ авах шаардлага бий болж байна. Тухайлбал, цахилгаан дамжуулах шугамын нөлөөгөөр олон улсын улаан дансанд бүртгэгдсэн махчин шувууд их хэмжээгээр эндэж буй нь талаар [3], [4], [5] судалгааны бүтээлд дурджээ. Мөн шувуудын үржлийн газар хумигдах, усны шувуудын хувьд усны нөөц багасах зэрэг асуудлууд тулгарч байна [6].

Монгол орны шувууны олон төрөл зүйл нь олон улсын хэмжээнд хамгаалалтад авах шаардлагатай ангилалд багтаж байгаа нь анхаарал татаж байна. Олон улсын Байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны Улаан дансанд бүртгэгдсэн шувуудын дунд *Falco cherrug* (идлэг шонхор), *Grus leucogeranus* (цагаан тогоруу), *Aquila nipalensis* (хээрийн бүргэд) зэрэг ховор болон устах аюулд орсон зүйлийг багтааж болно [6]. Тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах,

судалгаа хийх, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх нь Монгол Улсын хувьд шувуу хамгааллын гол зорилтуудын нэг болоод байна.

Иймд энэхүү өгүүлэлд Монгол орны шувуудын бүс нутгийн болон дэлхийн түвшний хамгааллын ач холбогдлыг тодруулан авч үзэж, тэдгээрийг хамгаалахад шаардлагатай арга хэмжээний талаар судалгаанд суурилсан дүгнэлт хийхийг зорьж байна. Мөн олон улсын шувуу хамгааллын байгууллагуудын хамтын ажиллагаа, судалгааны шинэ чиг хандлага, хамгааллын бодлогын хэрэгжилтийн талаар авч хэлэлцэх болно.

Үр дүн

Монгол орны шувуудын олон янз байдал: Монгол бол өргөн уудам газар нутагтай, байгалийн олон янзын бүс бүслүүр, ландшафттай тул шувуудын баялаг, өвөрмөц онцлогтой орон юм. Одоогоор Монгол оронд 23 багийн 70 овгийн 237 төрлийн 519 зүйлийн шувуудыг бүртгээд байна [7]. Экологийн төлөв байдал, оршин амьдрах хэлбэрийн хувьд авч үзвэл Монгол орны шувууны дийлэнх хэсгийг нүүдлийн үедээ дайран өнгөрдөг (PM) 291 зүйл (36%), Нүүдлийн өндөглөдөг (BV) 277 зүйл (34%), тохиолдлоор таарах (VA) 101 зүйл (12%), суурин үржлийн (RB) 81 зүйл (10%), хагас нүүдлийн (PrM) 41 зүйл (5%), өвөл орж ирдэг (WV) 15 зүйл (2%) болон үржлийн бус, зусдаг (NB) 8 зүйл (1%) гэж ангилна.

Монголд оронд хэд хэдэн зүйл Оросоос ирж өвөлждөг бөгөөд үүгээр зогсохгүй манай орон олон улсын нүүдлийн шувуудыг хамгаалахад чухал бүс нутаг болно.

Монгол орны шувууд тал хээр, говь цөл, цөл, уулын хээр, өндөр уул, ойт хээр, ус намгархаг газар гэсэн олон янзын амьдрах орчинд тархан амьдардаг. Тал хээрийн бүсэд орших шувуудаас шилийн сар, хээрийн бүргэд, идлэг шонхор, өвөгт тогоруу, хонин тоодог, монгол болжмор (**1-р зураг б**) зэрэг нь тухайн экосистемийн түлхүүр зүйлүүд болно. Цөлийн болон говь цөлийн амьдрах орчинд дасан зохицсон шувуудаас говийн ногтруу, жороо тоодог, зэвэн хиазат, цөлийн чогчиго, Монгол хуланжороо, цөлийн зэржигэнэ, загийн боршувуу орно. Өндөр уулын ой модоор бүрхэгдсэн амьдрах

орчинд морин харцага, шивэр хөтүү, нургын сойр, хув бэгбаатар, гацуурын солбинхошуут, науманны хөөндэй, ятга шаазгай болон янз бүрийн тоншуул зэргийг олж болно. Өндөр уулын бүсэд цармын бүргэд, ооч ёл, алгайн хойлог, хахилаг, цагаан ахууна, цэвдгийн ахууна, тагийн хайруулдай, халзан галсүүлт, өгөөлэй шулганаа болон хэрмийн бялзуухай зэрэг багтана.

Ус намгархаг газар, эрэг орчмын амьдрах орчин Монгол орны баруун хэсэгт голчлон байрлах бөгөөд хойд болон зүүн бүс нутгийн нуур, гол дагуу ихэвчлэн усны шувуудаас хошуу галуу, хээрийн галуу, зэрлэг нугас, улаан хүзүүт шумбуур, цэн тогоруу, Монгол цахлай, алаг ээтэн, дорнын хулд тохиолдоно. Ховор шувуудаас бахим хошуут хурагч зүүн Монголын цөөн хэдэн ус намгархаг орчинд, борцгор хотон баруун Монголын цөөн тооны нууранд үрждэг нь эдгээр амьдрах орчныг хамгаалах нэн чухал хэрэгцээ байгааг харуулж байна.

Монгол орны шувууны анги зүйлийн баялаг их хэдий ч, шувууны популяцид хэд хэдэн аюул заналхийлэл учраад байна. Түүний дотор хөдөө аж ахуйн тэлэлтийн улмаас амьдрах орчны алдагдал, хотжилт, уур амьсгалын өөрчлөлт, хүн-зэрлэг ан амьтдын мөргөлдөөн орно.

Шувуудын төрөл зүйл, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалахад тусгай хамгаалалттай газар нутгийг бий болгох, олон нийтийн оролцоо, санаачлага зэрэг байнга хамгааллын хүчин чармайлт чухал. Түүнчлэн шувууны популяцийн чиг хандлагыг хянах, тэдний экологийн үүргийг ойлгохын тулд экосистемийн үйлчилгээний талаар судалгаа хийх шаардлагатай байна. Жишээлбэл, хортон шавжтай тэмцэх, үр тараах зэрэг орно. Эдгээр асуудлуудыг арилгаснаар цаашдын судалгаанууд байгаль хамгаалах илүү үр дүнтэй стратегид хувь нэмрээ оруулж, хамтран ажиллах, Монголын шувуудын тогтвортой байдлыг хангах боломжтой юм.

Хамгаалал: Монгол улс шувуудын олон янз байдлын хувьд хэд хэдэн давуу талтай. Түүний дотор хөндөгдөөгүй, олон янзын байгалийн амьдрах орчин, хүний нөлөө бага, усны шувуудыг бага хэмжээгээр агнадаг. Үүний үр дүнд олон төрлийн шувуудын байнгын оршин суух эсвэл

улирлын нүүдлийн үед амрах хамгийн аюулгүй газар болдог. Манай орны шувуу судлаачид нэн ховор, ховордсон шувуудын зүйлийг үнэлж, дэлхийн хэмжээнд хамгаалагдсан байдлыг харгалзан үзэж, улсын хэмжээнд нэн яаралтай хамгаалах шаардлагатай байгаа шувуудыг тодорхойлжээ. Нийт 35 зүйлийн шувуу “Монгол Улсын Улаан ном”-д бүртгэгдэн 2013 онд хэвлэгдсэн байна. “Монгол Улсын Амьтны тухай хууль”-ийн 7 дугаар зүйлд нэн ховор найман зүйл шувуу орсон ба борцгор хотон (*Pelicanus crispus*), бахим хошуут хурагч (*Paradoxornis heudei*), цагаан тогоруу (*Grus leucogeranus*) (**1-р зураг а**), ямаан сүүлт нугас (*Oxyura leucocephala*), могойч загалай (*Circaetus gallicus*), бор бүргэд (*Clanga clanga*), цагаан сүүлт нөмрөг бүргэд (*Haliaeetus albicilla*) болон реликт цахлай (*Larus relictus*) зэргийг дурьдаж болно.

2007 оны байдлаар Монгол Улс нийт 70 газрыг олон улсын Шувуудад Чухал Нутаг (ШЧН)-аар тогтоосон бөгөөд ойролцоогоор 790'557 га буюу улсын нутаг дэвсгэрийн 5 хувийг эзэлдэг. Үүнээс 23 ШЧН нь бүрэн тусгай хамгаалалттай газар нутагт хамаарна, 6 нь хэсэгчлэн хамрагдсан, 40 нь хамгаалалтад ороогүй хэвээр байна. Монгол Улс 1994 онд CITES-ийн конвенцид нэгдэн орсон бөгөөд 71 зүйлийн шувууг хавсралтуудад оруулсан байна. Үүнд: усны нөмрөг бүргэд, эгэл шонхор, жороо тоодог, борцгор хотон, байгалийн нугас, халбаган хошуут, хар өрөвтас, үлэг харцага, цармын бүргэд, тарважи бүргэд, шилийн сар, сохор элээ, саарал хулд, ооч ёл, нөмрөг тас, идлэг шонхор, начин шонхор, өвөгт тогоруу, эгэл шаршувуу, соотон гуйванга гэсэн шувууд орсон

байна.

Манай оронд шувууны зүйлээс Идлэг шонхорыг хамгийн олон тоогоор олон улсад худалдаалсан тоо баримт бий. Байгаль орчны төлөв байдлын тайлан, олон улсын конвенцын тайлан зэрэг албан бичигт дурдсанаар нийт 3836 бодгалийг 1995-2015 онд Арабын улс орнууд руу арилжааны зорилгоор экспортлож эхэлсэн. Соёлын зориулалтаар 2015-2024 оны хооронд нууцын зэрэглэлд оруулан шинжлэх ухаан, бэлэглэлийн журмаар нийт 2430 бодгалийг гаргасан байна. Иймд тус зүйл шувууны тархац, тоо толгойн хэлбэлзлийг тогтоох, нөөцийг үнэлэх ажлыг улсын хэмжээнд 3-5 жилд тогтмол хийх зайлшгүй шаардлагатай.

Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газрын тухай, ялангуяа усны шувуудын амьдрах орчны тухай Рамсарын конвенц нь дэлхийн хэмжээнд ус намгархаг газрыг хамгаалах, тогтвортой ашиглахад чиглэгддэг. Монгол улс 1998 оны 4-р дугаар сарын 8-д Рамсарын конвенцид нэгдэн орсон бөгөөд одоогийн байдлаар 11 ус намгархаг газар бүртгүүлсэн байдгаас 7 нь УТХГ нутагт хамаарагдана. Үүнд Монгол Дагуур, Их нууруудын хотгор, Өгий нуур, Тэрхийн цагаан нуур, Айраг нуур, Хар-ус нуурын байгалийн цогцолборт газар, Ачит нуур орчмын ус намгархаг газар, Буйр нуур орчмын ус намгархаг газар, Ганга нуур орчмын ус намгархаг газар, Увс нуур орчмын ус намгархаг газар, Хурх-Хүйтэн голын хөндийн нуурууд бүртгэгдсэн байна.

Олон улсын байгаль хамгаалах холбооны улаан дансны ангилал, шалгуурын дагуу Монгол орны шувуудын 10% нь ховордсон ангилалд орсон, ховордож болзошгүй хамрагдана. Цаашилбал,



1-р зураг. а. Нэн ховор Цагаан тогоруу (*Leucogeranus leucogeranus*).




б. Монгол болжмор (*Melanocorypha mongolica*).

0.6% нь нэн ховордсон (CR), 1.7% нь ховордсон (EN), 3.3% нь эмзэг (VU), харин 4.4% нь ховордож болзошгүй (NT) ангилалд багтдаг. Монгол орны шувуудын бараг 90 % нь анхааралд өртөхөөргүй (LC) гэсэн ангилалд багтдаг нь хамгааллын статус өндөртэй шувууны популяцийг хянах, хамгаалахын тулд хэрэгжүүлж буй байгаль хамгааллын судалгаа, төслүүдийн ач холбогдлыг онцлон тэмдэглэв.

Нүүдэл: Дэлхийд шувуудын нүүдлийн найман гол зам байдгаас гурав нь Монгол орноор дайран өнгөрдөг: зүүн Ази-Австралын, төв Ази, баруун Ази-зүүн Африкийн гэсэн нүүдлийн гол замууд байна (**2-р зураг**). Монгол бол өргөн уудам газар нутагтай, байгалийн олон янзын бүс бүслүүр, ландшафттай тухайлбал нуга намаг, тал хээр, өндөр уулархаг газар нь эдгээр шувуудын үржих,

чухал ач холбогдолтой нутаг юм. Тогоруу, галуу, махчин шувууд нүүдэллэхэд Монголын орны онгон байгалиас ихээхэн хамаардаг. Тухайлбал, Монгол орны тал хээр, ус, намгархаг газар, ялангуяа Дагуурын хээр, Нууруудын хөндий олон тооны нүүдлийн шувуудыг тэтгэдэг.

Сүүлийн үед манай оронд усны шувуудын нүүдлийн хэв маяг, нүүдлийн замналын судалгаа ихээхэн хийгдэж байна. Тухайлбал Хошуу галуу (*Anser cygnoid*) зүйл дээр хийгдсэн судалгаанаас дурдвал: тус зүйл нь Монгол, Хятадын зүүн хойд хэсэг, Оросын алс дорнодын ус, намгархаг газар нутагт үржиж, зөвхөн Хятадын Хөх мөрний дунд болон адаг хэсэгт очиж өвөлждөг байна. Хошуу галуу нь олон янзын үржлийн амьдрах орчинд дасан зохицдог боловч ганд өртөмтгий гандуу бүс нутгийн




2-р зураг. Дэлхийн шувуудын нүүдлийн замын газрын зураг

нүүдлийн үедээ амрах, хооллох нэн шаардлагатай нөхцлийг бүрдүүлдэг. Энэ нь Монгол улсыг дэлхийн шувууны нүүдлийн сүлжээний чухал холбоос болж, нүүдлийн шувуудын популяцийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэж байгааг онцолж байна.

Монгол орны газарзүйн байршил нүүдлийн шувуудын хувьд хойд Азийн үржлийн газраас өмнөд Азийн өвөлжих нутаг хүртэл хол зайд нүүх явцдаа амрах, хоол тэжээлээ сэлбэх, үржих стратегийн

усан сан, ус намгархаг газрыг ихэвчлэн ашигладаг. Тэдний тоо толгой цөөрч, үржлийн, өвөлждөг нутаг нь хумигдсаар байгаа нь байгаль хамгаалах талаар цаашид ихээхэн анхаарал хандуулах шаардлагатай болохыг харуулж байна [8].

Сансрын дамжуулагчийн үр дүнгээс харахад өөр өөр бүс нутагт үрждэг Баруун Монгол, Төв Монгол, Дагуурын бүс нутгаас гаралтай хошуу галууны тус тусдаа нүүдлийн замаар нүүдэг ч эцэст нь Хөх мөрний адаг хэсэгт өвөлждөг болохыг тогтоожээ.



3-р зураг. Хошуу галууны (*Anser cygnoides*) намрын нүүдлийн зам ба амрах газрууд

Баруун Монголын Хошуу галуу нүүдлийн үедээ алс хол зам туулдаг хэдий ч, Дагуурын хошуу галуу нүүдлийн замдаа удаан хугацаагаар амардаг тул өвөлжих нутагтаа хожуу ирдэг. Бүх популяциудын хаврын нүүдэл илүү хурдацтай явагдаж, шувуудын намрын нүүдлийн хугацаатай харьцуулахад бараг хоёр дахин хурдан нүүсэн байна.

Эдгээр дамжуулагчийн судалгаанаас гарсан чухал дүгнэлт бол Хошуу галуу нүүдлийн үедээ олон ус намгархаг газрыг ашигладаг (хооллох, амрах газар) боловч эдгээр нь ихэвчлэн тусгай хамгаалалттай газраас гадуур байдаг. Эдгээр хамгаалалтад ороогүй ус, намгархаг газар нь тухайн зүйлийн оршин тогтноход, ялангуяа ган гачиг тохиосон, амьдрах орчин хүрэлцээгүй үед зайлшгүй шаардлагатай нутаг юм. Э д г э э р газар нутгийг хамгаалалтад аваагүй байгаа нь Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд шувуудын нүүдлийн гол түшиц газруудыг хамруулах шаардлагатай байгааг харуулж байна. Энэ нь зөвхөн Хошуу галуу төдийгүй эдгээр экосистемд байдаг бусад олон зүйл нүүдлийн шувуудад ач холбогдолтой байх болно (3-р зураг).

Монгол Улс намгархаг газрыг хамгаалахад голлон анхаардаг Рамсарын конвенц, Нүүдлийн зүйлийн тухай конвенц зэрэг олон улсын гэрээ хэлэлцээрт оролцож байгаагаас нь харахад шувуу хамгааллын төлөөх амлалт тодорхой харагдаж байна. Монгол Улс нүүдлийн шувуудад нэн чухал байдаг 1.4 сая гаруй га намгархаг газрыг хамарсан Рамсарын 11 цэгийг тогтоосон. Гэсэн хэдий ч эдгээр хамгаалалттай бүсээс гадуур байрлах шувуудын нүүдлийн коридоруудын хувьд асуудалтай хэвээр байна. Хятад, Орос зэрэг хөрш зэргэлдээ орнуудтай хил дамнасан байгаль хамгаалах хамтын ажиллагааг бэхжүүлэх нь эдгээр гол зам дагуу нүүдлийн шувуудын төрөл зүйлийг авч үлдэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Шувуулахуй: Монголчууд эртнээс шувуугаар ан хийлгэх “шувуулахуй” урлагийг хөгжүүлж ирснийг эртний ном судруудад олонтой дурдсан байдаг. Шувууг ан авд сурган ашиглаж байсан уламжлалт үеийн оргил нь XII-XIII зуун байсан юм. Жуулчин Марко Поло бичсэн номынхоо “Махчин шувуугаар ан хийх монголчуудын урлаг” гэсэн бүлэгтээ монгол цэргийн жанжин нар хавар,

намрын улиралд цэргийнхээ сүлд хийморийг сэргээхийн тулд дагуулан авд мордохдоо 1000 шонхор, 500 харцагатай гарч агнуурын шувуу олноор цуглардаг газрыг бүслэн авч анч шувуудаа хөөргөн усны шувуу авладаг гэжээ. Энэхүү уламжлалыг хэдийнээ мартаж, харин гадаад орнуудад энэ “спорт агнуур” ихээр түгэн дэлгэрч байгааг анхаарууштай юм.

Агнуурын шувууд: Монгол орон агнуурын шувууны зүйлийн тоогоор харьцангуй баян, нөөц баялаг ихтэй юм. Монгол орны агнуурын шувуудыг нүүдлийн, усны ба хөлдүү түүхий эдийн бэлтгэлийн гэж ангилан үздэг. Энэ нь тухайн зүйл шувууг тус нутагт оршин байх онцлогоос шалтгаалан гаргасан ангилал юм. Манай улсын хөлдүү түүхий эдийн бэлтгэлд тахиатан, тагтаатаны багийн шувууд зонхилох байр суурийг эзэлдэг. Манай орны тагтаатаны багт өнөөгийн байдлаар 2 овог, 3 төрөлд багтах 10 зүйл шувуу байгаагаас агнуурын нөөцтэй шувуунд дорнын хүүрзгэнэ, монгол ногтруу хамаарна.

Тахиатны багийн 2 овог 9 төрөлд хамаарах 12 зүйл шувуудаас 2-оос илүүгүй нь нүүдлийн ба бусад нь суурин амьдралтай. Суурин шувуудаас нь ердийн сойр тун ховор. Тахиатнаас алгайн хойлог, зэрлэг гургуул Монгол улсын Улаан номонд орсон ховордлын зэрэглэлтэй. Тиймээс хар хур, нургийн сойр, шивэр хөтүү, цагаан ба цэвдгийн ахууна зэрэг хурынхан болоод дагуур ятуу, эрэнхавирга хахилаг мэтийн гургуулын овгийн шувууд жинхэнэ хөлдүү түүхий эдийн бэлтгэлийн шувуудын гол цөмийг бүрдүүлсээр иржээ.

Хөлдүү түүхий эдийн бэлтгэлийн агнуураас гадна нүүдлийн агнуурын шувуу агнах өөр нэг ан агнуур байдаг. Манай оронд усны агнуурын болон спорт агнуурын ач холбогдолтой 120-иод зүйл шувуу өргөн тархаж, тоо толгойн хувьд элбэг байгаа билээ. Тоодог, галуу, нугас зэрэг нүүдлийн ба усны шувуудыг хавар, намрын цагаар нүүдлийн үед нь агнах уламжлал олон улс оронд байдаг. Галуу, нугас зэрэг усны шувууг зөвхөн хавар шувууд ирснээс хойш 5 сарын 15 хүртэл намар 8 сарын 15-наас буцах хүртэлх хугацаанд авлаж болох ба харин 5-р сарын 15-наас 8-р сарын 15 хүртэлх хугацаа бол үүр засах, өндөг дарах,

дэгдээхэйгээ бойжуулан өсгөх хугацаа учраас агнахыг хориглосон [9].

Эдгээр нүүдлийн шувууд тухайн нутгийнхаа биологийн гарцыг идэж, өөртөө ашиглан өсөж томроод, тарга хүч аваад буцдаг. Ер нь манай нутагт үржиж олшроод зүүн өмнөд Ази ба Газар дундын тэнгисийн бүс нутагт очиж агнагддаг энэ шувуудыг гадаадын анчдаар өндөр үнээр агнуулах, спорт ан агнуурыг хөгжүүлэх ажил зохиох нь чухал байна.

Гэсэн хэдий ч амьтдыг ашиглахын тулд тэдгээрийн амьдралын онцлог, байгаль дахь тоо толгой, тархац нөөцийн судалгааг тогтмол нарийн зохион байгуулахгүй бол байгаа баялгаа хэт цөөрүүлэх аюулд хүргэж болно. Иймээс өөрийн орны агнуурын ач холбогдол бүхий шувуудын нөөц баялаг чухам ямар хэмжээтэй байдгийг судлан тодорхойлж, ховордсоныг нь хамгаалах, агнуурын нөөц ихтэйг нь ариг гамтай, зөв зохистой ашиглахын тулд үндсэн зүйл шувуудыг таньж, тооллогыг улс даяар заагдсан нэгэн арга зүйн дагуу хийх хэрэгтэй байна.

Хэлэлцүүлэг, дүгнэлт

Олон янз байдал: Монгол орны шувуудын зүйлийн бүрдэл жил ирэх тусам нэмэгдсээр байна тухайлбал 2019 оны бүтээлд 513 зүйл тэмдэглэгдсэн [10] бол 2022 он гэхэд 519 зүйл албан ёсоор бүртгэгдсэн [7]. Үүнээс хойш 2 зүйл галуу шинээр тэмдэглэгджээ. 2023 онд Баянхонгор аймгийн нутагт орших Бөөнцагаан нуурт *Branta ruficollis*, 2024 онд тус аймагт *Branta canadensis*-г бүртгэжээ. Ховор шувуудын сүүлийн үеийн мэдээллээс дурдвал олон улсын байгаль хамгаалах холбооны улаан дансанд эмзэг ангилалд багтсан [11] Алаг тогоруу манай оронд 1929 онд анх тэмдэглэгдсэн бөгөөд үүнээс хойш нийт 22 удаагийн тохиолдлоор 59 бодгаль бүртгэгджээ. Анхны үржлийн хосыг 2021 онд Дорнод аймгийн Нөмрөгийн дархан цаазат газарт баталгаажуулан үржлийн шинэ цэгийг илрүүлжээ [12]. Шувуу ажиглагч, судлаачдын тоо нэмэгдсэнээр цаашид монгол орны шувуудын зүйлийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа билээ.

Хамгаалал: Монгол орон шувуудын амьдрах

орчныг хамгаалах, шувуудын зүйлийг хамгаалах хэд хэдэн конвенцод нэгдэн орсон байдаг. Жишээлбэл Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES), Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах конвенц (CMS), Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газрын (Рамсар) конвенцод нэгдсэн. CITES, CMS-ийн конвенцын хавсралтад бүртгэгдсэн шувууд дээр хамгааллын болон сургалт сурталчилгааны ажил идэвхтэй хийгддэг хэдий ч шувуудад чухал газруудад хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, олон нийтэд танин мэдүүлэх сургалт сурталчилгааны ажил тун хомс байна. Түүнчлэн Шувуудад чухал 70 газар (IBA) тодорхойлсон [13] байгаа хэдий ч цаашид шинэчлэн гаргаж тусгай хамгаалалттай газар нутагт хамруулан хамгаалалтад авах шаардлагатай байна.

Нүүдэл: Монгол улс Арктик, Төв-Ази болон бусад бүс нутгийг холбосон олон зүйлийн шувуудын нүүдлийн үндсэн зам болж, дэлхийн биологийн олон янз байдлын холбоосыг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Нийт шувуудын зүйлийн бүрдлийн 80 орчим хувийг нүүдлийн шувууд бүрдүүлдэг нь нүүдлийн шувуудын хувьд чухал газар нутаг болохыг харуулж байна. Нүүдлийн шувуудын томоохон төлөөлөл болох эргийн шувууд, усны шувууд, жижиг шувуудын нүүдэл популяцийн судалгаа сүүлийн жилүүдэд цөөнгүй хийгдэж ахиц гарсаар байна. Эргийн шувуудын нүүдэл, тоо толгойн судалгааг Чух шувуу судлалын суурин [14] болон Өгий ус намгархаг газрын судалгааны сууринд, Passeriformes болон бусад багуудын жижиг шувуудын нүүдлийн судалгааг Хурх болон Ховд шувуу бөгжлөх сууринд тогтмол явуулж байна. Шувуудын нүүдлийн замуудаас хамгийн том болох Зүүн-Ази Австрали-Азийн нүүдлийн зам нь манай орны төв ба зүүн хэсгийг дайран өнгөрдөг. Энэ нүүдлийн замаар жилд 492 зүйлийн 50 сая орчим шувууд нүүдэллэдэг ч сүүлийн жилүүдэд тоо толгой нь буурсаар байна [15]. Тиймээс шувуудын нүүдлийн замдаа бууж амардаг чухал газруудыг хамгаалалтад авах шаардлагатай байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн “Алсын хараа-2050” бодлого, дунд хугацааны “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эдийн засгийг тэлэх 14 мега төсөл хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд боомтын сэргэлт, авто болон төмөр зам, усан цахилгаан станц,

сэргээгдэх эрчим хүч /салхи/ зэрэг дэд бүтэцтэй холбоотой төслийг хамруулаад буй. Тиймээс цаашид дэд бүтцийн төслүүд хэрэгжүүлэхдээ шувуудад үзүүлэх нөлөөллийг сайтар судалж, экологи, нийгэмд ээлтэй арга техникийг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох шаардлагатай байна.

Ашигласан бүтээл

1. Yemtuu, B. (2020). The Physical Geography of Mongolia. <https://www.researchgate.net/publication/342591772>
2. Ganbold, O., Bing, G. C., Lee, J. H., Munkhbayar, M., Paik, I. H., Jargalsaikhan, A., Purevee, E., Purevdorj, Z., & Paek, W. K. (2018). An avifaunal survey of middle Mongolian wetlands: Important Bird Areas and threatened species. *Journal of Asia-Pacific Biodiversity*, 11(3), 340-345. <https://doi.org/10.1016/j.japb.2018.06.007>
3. Harness, R. E., & Gombobaatar, S. (2010). Perch discouragers and raptor electrocutions: Mongolian perspective. In *Proceedings of the International Conference on Southeastern Utility Pole*, February 22–23, 2010, Doubletree Downtown Memphis, Tennessee. Forest Products Society, USA, pp. 93-97.
4. Amartuvshin Purevdorj and *Gombobaatar Sundev. (2012). The assessment of high-risk utility lines and conservation of globally threatened pole nesting steppe raptors in Mongolia. *Ornis Mongolica the Journal of Ornithology*, 1, 2–12.
5. Dixon, A., Maming, R., Gunga, A., Purev-Ochir, G., & Batbayar, N. (2013). The problem of raptor electrocution in Asia: Case studies from Mongolia and China. *Bird Conservation International*, 23(4), 520–529. <https://doi.org/10.1017/S0959270913000300>
6. “The IUCN Red Lists of Threatened Species. Version 2023-1.” [Online]. Available: www.iucnredlist.org. (IUCN, 2023)
7. Gombobaatar, S. 2022. *Birds of Mongolia: Field Guide*. Vol.2. National University of

- Mongolia, Mongolica Publishing and Mongolian Ornithological Society. Ulaanbaatar, Mongolia. 488pp.
8. Iderbat Damba, Lei Fang, Kunpeng Yi, Junjian Zhang, Nyambayar Batbayar, Jianying You, Oun-Kyong Moon, Seon-Deok Jin, Bo Feng Liu, Guanhua Liu, Wenbin Xu, Binhua Hu, Songtao Liu, Jinyoung Park, Hwajjung Kim, Kazuo Koyama, Tseveenmyadag Natsagdorj, Batmunkh Davaasuren, Hansoo Lee, Oleg Goroshko, Qin Zhu, Luyuan Ge, Lei Cao, Anthony D. Fox. Flyway structure, breeding, migration and wintering distributions of the globally threatened Swan Geese *Anser cygnoides* in East Asia. *Wildfowl* (2020) Special Issue 6: 97–123. (SCI, IF 0, 762)
 9. Boldbaatar, Sh. 2018. The birds: series of science and knowledge (in Mongolian). Institute of General and Experimental Biology, MAS. Ulaanbaatar.
 10. Purewsuren, Ts. and Jargalsaikhan, L. 2019. Birds of Mongolia: A photographic guide (in Mongolian). Ulaanbaatar.
 11. BirdLife International (2025) IUCN Red List for birds. Downloaded from <https://datazone.birdlife.org> 24/03/2025
 12. Tseveenmyadag, N., Nyambayar, B., Tuvshintugs, S., Batmunkh, D., Jugdernamjil, N., Otgonbayar, Ts., Amarkhuu, G., Iderbat, D., 2022. New occurrence and breeding site of the Red-crowned crane *Grus japonensis* in Mongolia. *Toodog Mongolian Journal of Ornithology*. Issue 3. 2022, UB. P8. (in Mongolian)
 13. Nyambayar, B. and Tseveenmyadag, N. eds. (2009) Directory of Important Bird Areas in Mongolia: Key Sites for Conservation. Ulaanbaatar: Wildlife Science and Conservation Center, Institute of Biology and BirdLife International.
 14. T. Enkhzaya, T. Altangerel, G. Amarkhuu, S. Jiao, T. Oyunchimeg, and P.-O. Gankhuyag, “The migration of the *Tringa Linnaeus*, 1758 species at Chukh Lake, Eastern Mongolia”, *Proc. Inst. Biol.*, vol. 39, no. 2, pp. 109–125, Dec. 2023.
 15. Conklin, J. R., Verkuil, Y. I., & Smith, B. R., “Prioritizing migratory shorebirds for conservation action on the East Asian-Australasian Flyway,” p. 132, 2014.